

МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

СЭТГЭЛ СЭРГЭСЭН
1340 ХОНОГ

(Алмасын эрилчний тэмдэглэл)

Р. РАВЖИР

Бидний явсан газар бүхэнд аргал, янгирын баян сүргүүд нижгэнж, ишиг борлон, тэх, угалз сүргээсээ салан тусгаарлаж тавь, жараараа бэлчиж шөнийн цагт отгийн дэргэдэх аргамжаатай хөсөг, уналгыг бараадаж наран ургамагц сэмхэн зөөлөн холдохдоо харанхуйн дунд довтолж магадгүй ирвэс, чононд өртөөгүйдээ сэтгэл тааламжтай мэт эргэж харан шилгээсээр далд оровч, үзсэн нь мөн л бахь байдаг отог бараадах нь сүрлэг алтайн Тагт зэрлэг амьтад ч хүнийг хань бараа татах ажээ гэсэн бодол төрүүлнэ.

Бид газарчны хамт гэрэл гэгээ, дуу чимээ гаргахыг цээрлэн, чих тавин чимээ чагнасаар шөнийг өнгөрөөж мөн л аргал янгирын адил ургах нарнаар уулын хяр өөд хоёр хүрэн хайнагаа бартаанд хөтлөн цагаанд нь унасаар хөл алдагч асганы салтаа тулам цасанд мацаж хөвсөөр алсын бараа тодхон элгэн улаан цохиодын хярд гарч дурандан сууна. Өвлийн цагт бол цав цагаан цаасан дээр бараан зүст, хүн дүрст амьтан гарч ирэхийг ширтэн, алмасын мөр явж өнгөрснийг горилно.

Мөнх цасны чийглэг амьсгал цээж дүүрэн тэлж, уушигны гуурсанд өчүүхэн ч цэргүй мэт яруухан амьсгалж, цан хүүрэг татсан хүйтэн булгийн ус залгилахад бүлээн ажээ.

Нэгдлийн агуулахаас хэд хоногийн урьд авч гарсан хүнсний зүйл хоног, хоногоор багассан боловч баян Алтайн налгар хярд ятуу, ахууна, чандага, туулайнхаас өгсүүлээд хоол юунд тасрах билээ. Өнгөрсөн хоёр жилийн өмнө тохиолдсон үйл явдал бидний сэтгэлийг өөрийн эрхгүй эзэмдэнэ. 1973 оны 7-р сарын 1-нд юмсан. Аяны замаа эхлэхээр бэлтгэсэн тэр шөнө Толбо сумын зочид буудлын намхан цагаан байшинд амрахаар хэвтэцгээсэн боловч сэтгэлийн хөдөлгөөнд ноёлогдох нойр хулжин:

— Хүний өвгийг судлах миний зорилго чухам юугаар төгсдөг бол Алтай-Хангайгаа хүний өвгийн эх нутаг болгон дэлхий дахинд зарлуулчихвал азай буурал өвгөн миний амьд явсны хэрэг гүйцэх нь тэр. Дэлхий дахинд олдоогүй хүн гөрөөсийг тийм ч амархан барихгүй нь мэдээж, домог ба нутгийн хүмүүсийн яриагаар бол ер бусын шидтэн, чадалтан, тэр ч байтугай сонсох, харах, үнэрлэх эрхтэн хүнээс илүү хөгжсөн ч гэх шиг ямар нэг амьтныг хармагц биеэ маш хянамгай нууж чаддаг гэх мэт яриа нь ямар ч гэсэн ирвэс, барсны ангаас хэд дахин илүү чадал, самбаа тэсвэр, зориг шаардах болно. Хүн дүрст хүнчилж явдаг тэр амьтан бүх биендээ ноолуурхаг үстэй, Алтайн эрс тэс байгалд нэвтэр хий дассан болох нь илэрхий гэх мэтээр алмасын тухай энгийн ч юм шиг бүр аймшигтай ч юм шиг яриа нэг ёсондоо адал явдалт кино мэт үргэлжилсээр үүр цайхаас өмнөхөн босоод Толбо сумын орчмын уулсын хяр өөд харахад Которжон, Сайрын хүрэн хайрхан, Хөшиглөн гэх мэт тэнгэр баганадам сүндэрлэх сүрлэг өндөр уулын оргилууд цав цагаан цасан хучлагаа хөдөрч уулын бэл, тал хөндийгөөр бороо орсон байлаа. Бид яаралтай хөдөлж Хөшиглөнгийн хярд гарахаар мацсаар байгаад их үд өнгөрөхийн үед оргилд нь гарлаа, тэндэх цас хайлж зөвхөн хярд нь хэсэгхэн санчиг цас үлдэж түүний хайлж байгаа сэжүүр дээр алмас Хоёр гишгээд нойтон шалбааганд хальтарч унаад уулын арын асга гатлан

алга болсон байлаа. Хөлийн улны урт нь 33,5 см, өсгийний өргөн нь 9 см, өлмийн өргөн 13 см, эрхий хуруу саланги хөлийн ул нь шалбаа ганд гүнзгий шигдсэнээс майга хөлтэй болох нь тодхон харагдана. Тэр хүн дүрст амьтан хальтарч унахдаа 44 см урт үс нэг, 4 см орчим, урт үс 1 ширхэгийг үлдээжээ. Бид гишгэсэн мөрний фото зургийг авч үдшийн сэрүүн болтол хүлээгээд уул шалбааг царцмагц мөрний хонхорхойд гипс цутгаж хэв аваад яаралтай шуудангаар БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч байсан доктор Б. Ширэндэв, Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга байсан доктор Д. Майдар, доктор Б. Ренчин нарт тайлан бичиж мөрний зураг ба гипсэн хэв тус бүр нижгээд хувийг явуулсанд Б. Ренчин гуай гипсэн хэвийг Польшийн «Оюутан» сэтгүүлд, фото зургийг Бельгийн хүн судлалын ухааны нэрт доктор Хайзальманст явуулжээ. Хориод хоногийн дараа Бельги эрдэмтний хариу захиа Б. Ренчин гуайгаар дамжин надад ирсэн юм. Хайзальманс хариу захидалдаа: —Хэрвээ Равжир та Америк нутгаар жуулчлаагүй бол үзээгүй байх. Өмнөт Америкт миний үзсэн нэгэн агуйн чулуу болтлоо хатуужсан шалны шавар дээр хэдэн түмэн жилийн өмнө гишгэсэн Неандерталь хүний мөртэй тун адилхан байна. Үүнээс үзэхэд Монгол-Алтайд Алмас (хүн гөрөөс) одоо хүртэл амьдарч байгаа гэдэгт эргэлзэх явдалгүй. Хэрвээ Алтайгаас алмасыг олвол саран дээр хүн бууснаас илүү сонин нээлт болно. Тийм нээлт хийхийн даваанд байгаа танд тун шаргуу амжилт хүсэе! гэжээ. 1974 оны зун Хайзальманс өөрийнхөө нэг номонд Монгол Алтайгаас Равжирын олсон алмасын мөр 33,5 см хөлийн урттай байгаа нь хэрвээ түүнийг хүн гэж бодвол 2 м 24 см өндөр бөгөөд түүнийг барьж аваад хувцаславал 52— 54 размерийн гутал өмсөх ёстой гэж бичжээ. 1973 оны 12 сарын 17-нд Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг Хатуугийн ам өгсөн малгайлан орж эхэлсэн шинэ цасан дунд алмасын шинэ мөр хайж нутгийн анчин Норовка мэргэний хамт гэлдэрч явлаа.

Улаан голоос гадна дөрвөн Булаг цутган орсон Хатуугийн голын давчхан хавцал ам өгсөхөд хоёр талын эгц өндөр уулын хажуу дахь хад цохионууд нурж өнхөрөм сүрлэг бөгөөд түүний ёроолуудаар жирэлзэн урсах хэсэг, бусаг хүйтэн булгийн усан дотор таван дэлбээ бүхий Цэнхэр цэцэг, бадриу зузаан ногоон навчсын хамт усны аяс даган нахилзаж ес эхлэх дөхсөн тэсгим хүйтэн жаварт цогцос нь цэмцийх нь сэтгэл татна.

Энд, тэнд асга нураан хурдалж байгаа, янгир, аргал, хадан зохионы бартаа даган мярааж байгаа Алтайн «төмөр сүүлт» толбот барс (ирвэс) эд бүхэн нь хэний ч нүдний харцыг булаахгүй яах вэ. Малгайлан орсон цасны ширхэг нарийсан ихсэж тэрхэн орчныг бүдгэрүүлж манар сан шуурган дунд тавин метрээс цаадхи холын бараа харагдахгүй болж эхэлтэл, бидний замын гудас даган явсан маш том эсгий гуталтай хүний мөр бидний нүдний харцыг булааж түүнийг мөрдтөл хориод метрийн дараа эсгий гуталтай хүний мөр биш алмасын хөлд довхорч наалдсан нойтон цасан бүрхэвч хөлөөс нь салж замын хажууд мулт үсрэн гишгэгдсэн талаараа дээш харан унасан тул түүний чүүчгэр урт хуруунууд өсгий, өмхий нь тод харагдана. Уул мөрийг манарсан цасан дунд мөрд сөөр эхний өдөр арван найман км, маргааш нь найман км мөрдөж, Ёлт уулын цасгүй хярд хүргээд мөр алдлаа. Алмас хүн, амьтанд харагдахгүйн тулд жалга өгсөж, уруудан бартаа дамжин явахдаа газрын өөд алхсан арван мөрний дундач алхааны цэвэр зай нь 92 см, газрын уруу явахдаа 54 см байлаа. Өөрөөр хэлбэл хөлийн улны урт гуч гаруй см-ийг нэмбэл газрын өөд 1 м 25 см, газрын уруу 85 см зайг хороохуйц гишгэдэг ажээ. Алмас нь газрын уруу датуу алхдаг нь ар сээрээрээ их

бөгтөрөөс болж цээж түрэгдэн ойр, ойрхон алхдаг болов уу гэж бодогдмоор байлаа. Түүнийг хоёр өдөр мөрдөхөд алмас нь вансэмбэрүү, эрээ Гомбо, артууз, алтан гагнуур гишүүнэ иджээ. 12-р сарын 17-ны үед Алтай нутгийн газрын хөрс таван см орчим зузаан хөлдсөн хөлдүүг таван сарвуугаа шигтгэн өм татан хажууд нь тавиад доор нь байсан алтан гагнуурыг авч идсэн нь түүний гарын бяраа чадал хичнээн их байсныг илчлэнэ. Энэ тухай Д. Майдар «Монголын түүх соёлын дурсгалт зүйлүүд 1982» номондоо Монголчууд хүний өвгийг судлах талаар өөрийн түүхтэй Хайгуулч Равжир алмасын мөрийг орж байгаа цасан дээр хоёр өдөр хорин зургаан км зайд мөрдсөн боловч цасгүй ууланд гаргаж мөрийг нь алджээ... гээд алмасын тухай бусад мэдээ, материалуудыг бичжээ. 1975 оны 3-р сарын 12-оос 21-нийг хүртэл Ховд аймгийн Ховд сумын хоёрдугаар бригадын нутаг Холбоо Салбанд Ховд аймгийн Буянт сумын харьяат Дулаахан, Чандмана сумын харьяат Нямжав, Ховд сумын харьяат Ханагат, Мэрээтхан, Навай, Калкавай, Матиднах нарын хамт олон тосолт хийж ес хоноод Салбангийн цагаан нуурын орчинд 21-ний шөнө наймуулаа хад, хадны ёроолд сахиж хоолоо. Үүр цайтал ямар нэг амьтан явж өнгөрсөн сэдэв мэдэгдсэнгүй учир үүрийн үнэгэн саарал гэгээ тусмагц би тамхи гарган шүдэнз зурах тэр үед миний дэргэдээс сар, сүр хийх чимээ сонсогдон холдлоо, долоон нөхөд маань юун чимээ сонсогдов гэсээр цугларлаа. Бид цөм дурандахад бидний баруун хярын асган дунд алмас явахыг олж харлаа. Тэр алмас асганаас цааш хэд алхсанаа биднийг эргэж хараад гарын сарвуугаа гадагш харуулан дээш татаж эгдүүцсэнээ газраас юм түүж идээд хадан дээр сандайлан баруун гараараа ташаагаа тулж байлаа. Бид түүний зургийг зурж, аппаратаар авч, алмаст ойртохоор мөлхтөл тэр хүн дүрст амьтан бидний дөхөж байгааг мэдэн үргэж, хоёр хадан цохионы хоорондуур том том, алхлан цааш орчихлоо. Бид мацсаар уулын хяр дээр гарсан боловч хаачсан нь үл мэдэгдэн бараа сураггүй алга болсон байлаа. Бидний харснаар хуруу орчим нимгэн духтай хацраа бүтээсэн сартгар хамартай орчмоороо даравгар амтай нүүрэндээ үсгүй урт сахал, хөмсөгтэй, толгойн үс хоёр шанаагаа даган унжсан, ар сээрээр бөгтөр өргөн цээж, шувтан бөгс, урт гартай хүрэн бор үстэй, майга хөлтэй эрэгчин амьтан байлаа. Энэ тухай Ж. Пүрэв «Зүрхний хилэн» (1982) номондоо анчин эр нэрээр уран зохиолын хэллэгээр товч, тодорхой бичсэн юм.

Энэ удаад алмасыг 1237 м зайгаас дурангаар харсан билээ. 1973 оны 7 сараас 1977 оны 3-р сарыг дуустал Монгол Алтайн хярд 1340 хоног аялах хугацаанд алмасыг 3 удаа харж мөрний зургийг 37 удаа авч, агуйд байрлаж байсан газраас өтгөн шингэн ялгадасыг олж Цамба гарав уулын мөнх цас, харын зааг дээр дошсон сарлагийн бухны баасан дээр гишгэсэн хөлний мөрний хэв гарсан аргал олж Шинжлэх ухааны академид өгсөн юм. Алмасын тухай домог яриа 70 гаруйг цуглуулж эмхтгэж байна. Энэ домог яриа XIX зууны эхэн үеэс Монголд үзэгдсэн алмасын тухай амаас ам дамжигдан ирсэн домгууд юм.

Ямар ч хүн өөрөө өөртөө итгэдэг. Нэгэнт ийм итгэл надад төрсөн болохоор зорилгоо биелүүлэхийн төлөө бололцоотой бүхнээ хийж, өнөө хүртэл нууц нь тайлагдаагүй хүн гөрөөс, түүний эрхийн тухай асуудалд өчүүхэн боловч хувь нэмэр оруулахсан гэдэг хүслэн өвөр мөсөөр...